

МОНГОЛ, ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ 60 ЖИЛИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

*Н.Төмөр**

Монгол Улс, БНХАУ-ын харилцаа улс төр, худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан технологи, соёл боловсрол, биеийн тамир спорт, эрүүлийг хамгаалах, олон нийтийн байгууллага зэрэг нийгмийн бүхий л салбарыг хамран амжилттай хөгжиж байна. Энэ онд хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг тэмдэглэх гэж байна.

1949 оны 10 дугаар сарын 1-нд БНХАУ байгуулагдсан. БНМАУ БНХАУ байгуулагдсаныг хүлээн зөвшөөрч 1949 оны 10 дугаар сарын 16-нд хоёр улсын хооронд албан ёсоор дипломат харилцаа тогтоосон. БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноор хоёр орны найрамдалт харилцаа бүх талаар өргөжин хөгжих шинэ хуудас нээгдсэн. 1952 онд “БНМАУ, БНХАУ-ын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулав. Хоёр улсын Засгийн газрын хооронд байгуулсан анхны энэ хэлэлцээр нь монгол, хятадын ард түмний найрамдалт харилцааны түүхэнд нэн чухал ач холбогдолтойг хоёр улсын удирдагчид тэмдэглэн хэлж байлаа.

БНМАУ, БНХАУ-ын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулснаас хойш хоёр талын харилцаа нэн идэвхижив. 1953-1959 онд хоёр орны хооронд шуудангийн хэлэлцээр, худалдааны зээлийн хэлэлцээр, шуудан телеграфийн хэлэлцээр, худалдаа ба төлбөрийн хэлэлцээр, радио нэвтрүүлгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, харилцан шуудангийн илгээмж солилцох хэлэлцээр, агаарын тээврийн хэлэлцээр, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр зэрэг 10 гаруй хэлэлцээрт гарын үсэг зурж хэрэгжүүллээ. Ингэснээр хоёр орны гэрээ эрхийн үндсүүд шинээр тавигдаж хамтын ажиллагааны баттай үндэс суурь бий болсон юм. 1960 онд “БНМАУ, БНХАУ-ын найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ” байгуулснаар БНМАУ БНХАУ-тай эрх тэгш, найрамдал, харилцан туслалцаж харилцах эрх зүйн өргөн боломж нээгдсэн нь нэн чухал ач холбогдолтой үйл явдал байлаа.

БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноор хоёр орны найрамдалт харилцаа бүх талаар өргөн хөгжих бололцоо бүрдсэн бөгөөд энэхүү харилцаа урагшлан хөгжихөд хоёр улсын хүчин чармайлт шаардлагатай байлаа. БНМАУ-ын Засгийн газрын хувьд бол харилцааг хоёр улсын ард түмнүүдийн эрх ашгийг илэрхийлсэн эрх тэгш зарчмын үүднээс хөгжүүлэхийг чухалчилж байв. 1949-1959 он

* Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

бол БНХАУ улс ардын аж ахуйгаа сэргээн босгох үе байсан бөгөөд хятадын ард түмэн улс орныхоо аж ахуйг сэргээн босгоход монголын ард түмэн бололцооныхоо хирээр туслан дэмжиж байсан. БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон эхний 10 гаруй жил бол хоёр орон, хоёр ард түмний эрх ашигт бүрэн нийцсэн он жилүүд байсан. Энэ хугацаанд хоёр улсын удирдагчид дээд хэмжээнд харилцаж, хоёр орны хооронд найрамдал, хамтын ажиллагааны гэрээ эрхийн үндэс суурь баттай тавигдсан байлаа. Хоёр улсын ард түмний дунд найрсаг, найрамдлын халуун дотно харилцаа бүрэлдэн БНХАУ-ын эдийн засаг, техникийн тусламж БНМАУ-ын бүтээн байгуулалт, улс ардын аж ахуйд зохих үүрэг гүйцэтгэж байсан.

1966-1976 онд БНХАУ-д болсон “Соёлын хувьсгал”-ын үед манай хоёр улсын харилцаа муудаж, энэ хугацаанд БНМАУ, БНХАУ-ын хооронд жил бүрийн харилцан бараа нийлүүлэх протокол, хоёр улсын төмөр замын хамтарсан комиссын хуралдаан, зарим нэг ёслолын арга хэмжээнээс өөр дорвитой ямар нэгэн арга хэмжээ болсонгүй.

1980-аад оны дунд үеэс манай хоёр улсын харилцаа хэвийн хөгжиж эхлэсэн. 1984 оны 9 дүгээр сард БНМАУ-ын ГЯЯ-ны сайд М.Дүгэрсүрэн, БНХАУ-ын ГЯЯ-ны сайд У Сюецень нар Нью-Йорк хотноо уулзаж, хоёр улсын харилцааг сайжруулж, хөгжүүлэх талаар саналаа солилцов. Энэ нь БНМАУ, БНХАУ-ын ГЯЯ-ны сайд нарын 20 гаруй жилийн дараахи анхны уулзалт байлаа. 1986 оны 8 дугаар сард БНХАУ-ын ГЯЯ-ны дэд сайд Лю Шуцин БНМАУ-д айлчилж, хоёр тал харилцан сонирхож байгаа асуудлаар санал солилцож БНМАУ, БНХАУ-ын Консулын конвенцид гарын үсэг зурав. 1987 оны 6 дугаар сард БНМАУ-ын АИХ-ын урилгаар БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын Хорооны орлогч дарга Пэн Чун тэргүүтэй БНХАУ-ын парламентын төлөөлөгчид БНМАУ-д албан ёсны найрсаг айлчлал хийж, хоёр орны хууль тогтоох дээд байгууллагын хоорондын харилцаагаа сэргээлээ. Дээрхи айлчлалын хариуд 1988 оны 9 дүгээр сард БНМАУ-ын АИХ-ын дарга Л.Ринчен тэргүүтэй төлөөлөгчид БХАТИХ-ын Байнгын Хорооны урилгаар БНХАУ-д албан ёсны найрсаг айлчлал хийв. Энэ нь 1960 оноос хойш БНМАУ-ын АИХ-ын төлөөлөгчдийн БНХАУ-д хийсэн анхны айлчлал болов.

1989 оны 3 дугаар сард БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн БНХАУ-д, мөн оны 8 дугаар сард БНХАУ-ын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь БНМАУ-д тус тус айлчиллаа. Харилцан айлчлалын дунд БНМАУ, БНХАУ-ын эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны комисс байгуулах тухай хэлэлцээр байгуулсан нь онцгой чухал ач холбогдолтой юм. Хоёр улсын харилцаа бүхий л салбарт өргөжин байгаа үед Засгийн газар хоорондын ийм байгууллага

байгуулах шаардлага зүй ёсоор урган гарсан билээ. Мөн иргэд харилцан зорчих журмын талаар протоколд гарын үсэг зурав. Айчлалын бас нэг үр дүн бол Хөх хотод БНМАУ-ын Ерөнхий консулын газрыг сэргээн байгуулахаар тохиролцсон явдал юм. 1957 онд Хөх хотноо БНМАУ-ын Ерөнхий консулын газар анх байгуулсан нь БНМАУ, БНХАУ-ын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж, тухайн үедээ хил орчмын малчид, нутгийн хүн амын дунд үүсч байсан зарим асуудлыг шийдвэрлэхэд болон иргэд харилцан зорчиход тус дөхөм болж байв. Дээр дурдсан хоёр айлчлал нь БНМАУ, БНХАУ-ын харилцаа гүнзгийрэн хөгжсөний илэрхийлэл болж, хоёр орны улс төрийн харилцааны түвшинг дээшлүүлэхийн эхлэл болсон юм.

1990 оны 5 дугаар сард БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Г.Очирбат БНХАУ-ын дарга Янь Шанкуний урилгаар БНХАУ-д айлчиллаа. Энэ айлчлал нь хоёр орны харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон бөгөөд БНХАУ-тай харилцах БНМАУ-ын гадаад бодлого залгамж чанартайг харуулж, БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох гэсэн олон жилийн хүчин чармайлтын тодорхой үр дүн болсноороо онцлог юм. БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбатын урилгаар БНХАУ-ын дарга Янь Шанкунь 1991 оны 8 дугаар сард БНМАУ-д албан ёсны айлчлал хийлээ. БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойшхи 42 жилд анх удаа БНХАУ-ын төрийн тэргүүн БНМАУ-д айлчилсан нь хоёр орны харилцаанд тэмдэглэгдэх үйл явдал болсон төдийгүй хоёр улсын харилцааг цаашид хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой томоохон алхам боллоо.

1994 оны 4 дүгээр сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны харилцааны түүхэнд шинэ хуудас нээлээ. БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Эньлай 1960 оны 5 дугаар сард БНМАУ-д айлчилж, “БНМАУ, БНХАУ-ын найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ” байгуулснаас хойш 34 жилийн дараа БНХАУ-ын Ерөнхий сайд Монгол Улсад дахин айлчилж, “Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” байгуулсан нь хоёр орны харилцааны тулгуур үндэс болсноороо түүхэн чухал ач холбогдолтой юм. “Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” бол Монгол Улс, БНХАУ-ын харилцааны туулсан туршлагад үндэслэж, харилцааны өнөөгийн хүрсэн түвшинг бататгаж, 21-р зуунд хоёр орны харилцааг хөгжүүлэх үндсэн тулгуур баримт болсон юм.

Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэний урилгаар 1996 оны 3 дугаар сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны харилцааны түүхэнд бас нэг тэмдэглэлт үйл явдал болсон юм. Хоёр улсын Ерөнхий сайд нар

хэлэлцээн дээр улс орныхоо эдийн засгийн өнөөгийн байдлын талаар харилцан мэдээлэл хийж, хоёр улсын харилцааны зарим тулгамдсан асуудал, харилцан сонирхсон бусад асуудлаар санал солилцов. Айлчлалын хугацаанд П.Жасрай, Ли Пэн нар “Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хоорондын эдийн засаг техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр”, “Монгол Улсын Шинжлэх ухаан боловсролын яам, БНХАУ-ын Боловсролын хорооны хоорондын боловсролын салбар дахь солилцоо, хамтын ажиллагааг 1996-2000 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө” зэрэг баримт бичигт гарын үсэг зурав.

БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар 2003 онд Монгол Улсад төрийн айлчлал хийсэн. Төрийн айлчлалын үеэр хоёр улсын хооронд “сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа”-г тогтоон хөгжүүлэхээ санал нэгтэй мэдэгдэв. Айлчлалын үеэр хоёр улс харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх, хамтын ажиллагааг олон салбар, сувгаар, төрөл бүрийн хэлбэрээр өрнүүлэн, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, байгалийн баялгийг ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны чухал салбар болгохоор тохиролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНХАУ-ын дарга Ху Жинтаогийн урилгаар 2005 онд БНХАУ-д төрийн айлчлал хийсэн. Айлчлалын үеэр гаргасан Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэлд, Монгол, Хятадын хооронд 2003 онд сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааг тогтоосноос хойш хоёр талын улс төрийн итгэлцэл хэлбэрэлтгүй нэмэгдэж, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа хурдацтай хөгжин, бүх салбарын харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт идэвхжиж байгааг тэмдэглэв.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улс, БНХАУ-ын хооронд өндөр, дээд хэмжээний айлчлалуудын давтамж ойртож ирсэн. Тухайлбал, БНХАУ-ын дарга Зянь Зэмин /1999 оны 7 дугаар сард/, Монгол Улсын Ерөнхий сайд Р.Амаржаргал /1999 оны 10 дугаар сард/, Монгол Улсын УИХ-ын дарга Р.Гончигдорж /2000 оны 3 дугаар сард/, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр /2002 оны 1 дүгээр сард/, БНХАУ-ын дарга Ху Жинтао /2003 оны 6 дугаар сард/, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди /2004 оны 7 дугаар сард/, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр /2005 оны 11 дүгээр сард/, Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд /2006 оны 11 дүгээр сард/, БНХАУ-ын дэд дарга Си Жиньпин /2008 оны 6 дугаар сард/, Монгол Улсын УИХ-ын дарга Д.Дэмбэрэл /2008 оны 12 дугаар сард/, Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр /2009 оны 4 дүгээр сард/ тус тус айлчлал хийсэн

байна. Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Баогийн форумд оролцон, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябаотой Саньяа хотод уулзав. Уулзалтын үеэр хоёр тал Монгол Улс, БНХАУ-ын найрамдалт харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар ярилцав. Ерөнхий сайд С.Баяр дэд бүтцийн болон байгалийн баялгийг ашиглах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрчим хүчний цогцолбор барьж БНХАУ-д цахилгаан эрчим хүч экспортлох, нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах талаар саналаа илэрхийлэв. Хоёр улсын хооронд тогтмол хийгдэж буй өндөр, дээд хэмжээний айлчлал, яриа хэлэлцээ нь хоёр орны бүх талын харилцаа, ялангуяа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тогтвортой хөгжилд чухал түлхэц үзүүлж байна.

Монгол, Хятадын найрсаг харилцаа хөгжсөнөөр хоёр улсын шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг, биеийн тамир спорт болон бусад салбарын харилцаа хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна. Монгол Улсын ШУА, БНХАУ-ын Нийгмийн болон Байгалийн ШУА, ӨМӨЗО-ны Нийгмийн ШУА-тай хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж газар зүй, геоэкологи, ботаник, палеонтологи, археологи, хэл утга зохиол, гүн ухаан, угсаатны зүйн чиглэлээр хамтран судалгаа хийж, тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх болов. Монгол Улсын ШУА, БНХАУ-ын Байгалийн ШУА-ийн хооронд цөлжилт, цэвдэг судлалаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулснаар орчин үед гол асуудал болж байгаа цөлжилт, түүнтэй тэмцэх талаар хамтарсан судалгаа явуулах нөхцөл бололцоог буй болголоо.

Монгол, Хятадын соёл урлаг, боловсрол, биеийн тамир спортын төлөөлөгчдийн харилцан айлчлалын тоо жилээс жилд нэмэгдэж, Хятад улсад зохиогдох олон улсын шинж чанартай соёл урлаг, биеийн тамир спортын арга хэмжээнд монголын урлаг соёлын зүтгэлтнүүд, нэрт дуучин жүжигчид, шилдэг тамирчид оролцон өндөр амжилт гаргасаар ирлээ. БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо зуны олимпын XXIX их наадам 2008 оны наймдугаар сард болж, Монгол Улсын тамирчид спортын долоон төрөлд 28 тамирчин оролцон, бокс, жүдо, буудлагын багийнхан өндөр амжилт үзүүлсэн. Монгол Улсад зохиогдох соёл урлагийн арга хэмжээнд болон олон улсын биеийн тамир спортын тэмцээнд хятадын уран сайхны хамтлаг, жүжигчид, дуучид, тамирчид байнга оролцдог боллоо. БНХАУ-д их дээд сургууль, дамжаа төгсөгчид, суралцагсадын Монголын холбоо, БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ хамтран жил бүр зохион байгуулдаг “Дорнын уянга” хятад дуу дуулаачдын уралдаан нь хоёр орны соёлын хамтын ажиллагааны нэг хэсэг болов.

Монгол, Хятадын боловсролын салбарын харилцаа хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж МУИС, МУБИС, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Улаанбаатарын их сургууль зэрэг их сургуулиуд Бээжингийн их сургууль, Бээжингийн гадаад хэлний их сургууль, Гадаад харилцааны их сургууль, Ардын их сургууль, Өвөр Монголын их сургууль, Өвөр Монголын багшийн их сургууль, Хэбэйн их сургууль зэрэг их дээд сургуулиудтай харилцаа холбоо тогтоож хамтын ажиллагаагаа өрнүүлж байна. Монгол Улс, БНХАУ хоёр улсын Засгийн газрын боловсролын салбарын харилцаа хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу байгуулагдсан МУИС-ийн Күнзийн институт нь өөрийн өвөрмөц онцлог бүхий сургалтын хийгээд соёлын үйл ажиллагаа явуулж, хятад хэлний сургалтын үйл хэрэгт тус дөхөм үзүүлж, Монгол, Хятадын боловсрол, соёлын харилцаа хамтын ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулахын төлөө чармайн ажилладаг боловсролын байгууллага юм. Монгол, Хятад хоёр улсын их дээд сургуулиудын төлөөлөгчид харилцан айлчилж, сургалтын туршлага солилцон, оюутнуудаа харилцан сургах явдал нь сургуулиудын хамтын ажиллагаа хөгжин бэхжиж буйн нэгэн илрэл болж байна.

Монгол Улс, БНХАУ-ын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгаа нь хоёр улсын язгуур эрх ашигт нийцэх төдийгүй, бүс нутгийн болон даян дэлхийн энх тайван, хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлэх нь дамжиггүй. Манай хоёр улсын улс төр, худалдаа эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан болон бусад салбарын хамтын ажиллагаа тогтвортой хөгжиж байгаа нь хөрш хоёр орны ард түмний уламжлалт харилцааг бататгах, бие биеийнхээ бодит байдлыг харилцан ойлгох, танин мэдэхэд чухал ач холбогдолтой.